



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
ЯАМАНД

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,  
http://www.mojha.gov.mn

2018.12.20 № 1-1/6193  
танай 2018.12.10 -ны № 01/5880 -Т

Улсын нэгдсэн бүртгэлд  
хөдөлгөөн хийсэн тухай

Танаас 2018 оны 01/5880 тоот албан бичгээр ирүүлсэн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны "Захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох тухай" 273 дугаар тушаалыг хүлээн авч дараахь тушаалуудыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлээс хасаж холбогдох хөдөлгөөн хийснийг мэдэгдье. Үүнд:

1. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 1759 дугаарт бүртгэлтэй Дэд бүтцийн сайдын 2001 оны "Агаарын зайг тогтоох тухай" 187 дугаар тушаал;

2. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 1814 дугаарт бүртгэлтэй Дэд бүтцийн сайдын 2002 оны "ИНД-67 Иргэний нисэхийн эрүүл мэндийн стандарт, гэрчилгээ" батлах тухай 26 дугаар тушаал;

3. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 1948 дугаарт бүртгэлтэй Дэд бүтцийн сайдын 2002 оны "Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлагууд ИНД-26" батлах тухай 353 дугаар тушаал;

4. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 1881 дугаарт бүртгэлтэй Дэд бүтцийн сайдын 1997 оны "Норм үнэлгээ батлах тухай" 131 дугаар тушаал;

5. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3027 дугаарт бүртгэлтэй Зам, тээвэр аялал жуулчлалын сайдын 2006 оны "Авто замын тээврийн хяналт зохицуулалт ОУ-ын болон улсын чанартай авто зам дээгүүр зорчиж буй тээврийн хэрэгслээс төлбөр хураан авах талаар журам" батлах тухай 127 дугаар тушаал;

6. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 723 дугаарт бүртгэлтэй Дэд бүтэц, хөгжлийн сайдын 1994 оны "Үйлчилгээний хөлсний хэмжээ тогтоох тухай" 174 дүгээр тушаал.



Ц.НЯМДОРЖ